

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

“Үнэт цаасны бүртгэлийн журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8.2, 10.16, 16.2, 17.2, 18.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам шинэчлэн батлах тухай” 38 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү журмыг олон нийтэд сурталчлах, бүртгэлтэй компаниуд, зохицуулалттай этгээдүүдийн хүрээнд сургалт зохион байгуулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/-д, Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар нийтэд санал болгон шинээр болон нэмж гаргах үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны үнэт цаасны бүртгэл /цаашид “үнэт цаасны бүртгэл” гэх/-д бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах, худалдах, үнэт цаасны гүйлгээний тайланг Хороонд ирүүлэх, нийтэд мэдээлэх, хувьцаат компани хуваагдах, нэгдэх, нийлэх, хуваах, өөрчлөх зэрэг хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан, хувьцааг хуваах, нэгтгэх, бондын үлдэгдлийг хүчингүй болгох зэрэг үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хувьцаат компани нэмж гаргасан хувьцаагаа нээлттэй, хаалттай захиалгын аль хэлбэрээр худалдахаар шийдвэрлэснээс үл хамаарч энэ журмын дагуу Хороонд бүртгүүлнэ.

1.3. Хороонд анх бүртгэгдсэн үнэт цаас анхдагч зах зээлд бүрэн арилжаалагдаж дуусах хүртэлх хугацаанд тухайн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэхийг хориглоно.

1.4. Үнэт цаасыг бүртгүүлэхэд тавигдах шаардлага болон бүрдүүлэх бичиг баримт нь тухайн үнэт цаасны төрөл, үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллаганы байдал, үнэт цаасыг гаргах хэлбэрээс хамаарч өөр байж болно.

1.5. Энэхүү журмаар хоёрдогч зах зээлд арилжаалагдаж буй үнэт цаасыг худалдах болон худалдан авах захиалгыг хүлээн авах, арилжихтай холбогдсон харилцааг зохицуулахгүй.

1.6. Хороонд бүртгүүлээгүй аливаа үнэт цаасыг нийтэд сурталчлах, үнэт цаасны зах зээлд арилжихыг хориглоно. Стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээд, андеррайтерийн компанитай үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах талаар урьдчилан яриа, хэлэлцээр хийснийг нийтэд санал болгон сурталчилсанд тооцохгүй.

1.7. Энэхүү журмыг Хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн, эсхүл бүртгүүлэхээр төлөвлөж буй аливаа үнэт цаас гаргагч, тэдгээрийн төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ГУЗ” гэх)-ийн гишүүн, эрх бүхий албан тушаалтан, андеррайтер, аудитор, хуульч, хөрөнгийн үнэлгээчин, үнэт цаас гаргахтай холбоотой холбогдох хөндлөнгийн шинжээч зэрэг мэргэжлийн зөвлөхүүд дагаж мөрдөнө.

1.8. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хорооноос тогтоосон журмаар зохицуулна.

1.9. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнийг Хорооны бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооноос тогтоосон журмаар зохицуулна.

1.10. Хадгаламжийн бичиг гаргах харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооноос тогтоосон журмаар зохицуулна.

Хоёр. Нэр томъёо

2.1. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар ойлгохоос гадна дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Хорооны бүртгэл” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, энэ журамд заасны дагуу Хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлийг;

2.1.2. “Хөрөнгийн биржийн бүртгэл” гэж энэ журамд заасны дагуу Хорооны бүртгэлд бүртгэгдсэн, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.1.2-т заасан журмын дагуу арилжаанд оруулах нөхцөл хангасан үнэт цаасыг бүртгэсэн хөрөнгийн биржийн бүртгэлийг;

2.1.3. “бүртгэлтэй үнэт цаас буюу бүртгэлтэй компани” гэж энэхүү журмын 2.1.2, 7.1, 8.1-т заасан бүртгэлд бүртгэгдсэн, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1-д заасан үнэт цаас буюу уг үнэт цаасыг бүртгүүлсэн компанийг;

2.1.4. “хүсэлт гаргагч” гэж Хорооны бүртгэлд бүртгүүлсэн, эсхүл бүртгүүлэх хүсэлт гаргаж буй хуулийн этгээд буюу үнэт цаас гаргагчийг;

2.1.5. “мэргэжлийн хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулах үнэт цаас” гэж тухайн үнэт цаасны онцлогоос хамаарч мэргэшсэн, хязгаарлагдмал тооны хөрөнгө оруулагчид (энэ журмын 2.1.7, 2.1.8-д заасан зэрэг)-ын дунд арилжаалагддаг үнэт цаасыг;

2.1.6. “холбогдох этгээд” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30-т зааснаас гадна дор дурдсан нөхцөлийг хангасан этгээдийг ойлгоно.

2.1.6.1. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхыг томилох эсхүл чөлөөлөх шийдвэрийг гаргах, эсхүл шийвэрлэх боломж бүхий этгээд;

2.1.6.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30.в-д заасан тухайн компанийн саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэггүй хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчидтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр дангаараа буюу тийнхүү тохиролцсон бусад хувьцаа эзэмшигчдийн хамт саналын эрхийн олонхийг хяналтандаа авсан этгээд;

2.1.6.3. тухайн компанийн хувьцааг эзэмшдэггүй боловч шийдвэр гаргах эрх буюу хяналтыг хэрэгжүүлж байгаа этгээд.

2.1.7. “Мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19-д зааснаас гадна дараах этгээдийг ойлгоно:

2.1.7.1. Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан Засгийн газрын тусгай сан;

2.1.7.2. зохицуулалт бүхий тэтгэврийн сан.

2.1.8. “мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчтэй адилтгаж үзэх этгээд” гэж тухайн этгээдийн хөрөнгө оруулалт хийх мэдлэг туршлага, хөрөнгийн хэмжээ, тухайн этгээдийн итгэмжлэн удирдах хөрөнгийн хэмжээ зэрэг хүчин зүйлийг харгалзан Хороонд бүртгүүлсэн дор дурдсан этгээдийг:

2.1.8.1. хувь нийлүүлсэн хөрөнгө нь 1 тэрбум төгрөгөөс багагүй байх бөгөөд уг хөрөнгө нь дараах байдлаар баталгаажсан компанийг;

2.1.8.1.1. аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн улирлын санхүүгийн тайлангаар баталгаажсан;

2.1.8.1.2. хуулиар санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулахыг шаарддаггүй компани бол, сүүлийн улирлын санхүүгийн тайлангаар компанийн санхүүгийн байдлыг үнэн зөв тусгасан талаарх баталгааг компани өөрөө гаргасан;

2.2. Хороо энэ журмын 2.1.7-д заасны дагуу хөрөнгө оруулалтын сан, андеррайтер, дилер, даатгал, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд, Монголбанк банкны үйл ажиллагаа эрхлэх этгээдэд, Засгийн газар 2.1.7.1-д тус тус дурдсан этгээдүүдэд хуульд нийцүүлэн тухайн мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчийн тухайд тодорхой журам буюу зохистой харьцаа тогтоож болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
ХОРОО, ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ЧИГ ҮҮРЭГ,
ГАДААД УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮНЭТ ЦААСНЫ
БҮРТГЭЛ, ДАВХАР БҮРТГЭЛ

Гурав. Хорооны чиг үүрэг

3.1. Хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу үнэт цаасны танилцуулгыг Хорооны бүртгэлд бүртгэнэ.

3.2. Хороо нь өөрийн бүртгэлд бүртгүүлсэн, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан үнэт цаас гаргагчид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, энэ журмаас гадна Хорооноос тогтоосон дор дурдсан дүрэм, журмаар тодорхойлсон шаардлагыг тавина:

3.2.1. үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулсан журам;

3.2.2. үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчээс үнэт цаасны зах зээл дээр явуулах харилцааг зохицуулсан журам;

3.2.3. компанийн хувьцааг худалдан авахтай холбоотой харилцааг зохицуулсан журам;

3.2.4. үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой бусад журам.

3.3. Хороо Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.1.4, 63.1.11-д заасны дагуу хөрөнгийн биржийн бүртгэлийн журмыг батлах зөвшөөрөл олгоно.

Дөрөв. Хөрөнгийн биржийн чиг үүрэг

4.1. Хөрөнгийн бирж нь өөрийн нөхцөл, шалгуурын дагуу үнэт цаасыг бүртгэх ба Хорооноос зөвшөөрсөний үндсэнд өөрийн зах зээл дээр арилжаалах зөвшөөрөл олгоно.

4.2. Хөрөнгийн бирж нь өөрийн зах зээл дээр арилжаалагдахаар зөвшөөрөгдсөн үнэт цаасны анхдагч ба хоёрдогч зах зээлийн арилжаа Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооноос баталсан дүрэм, журмын аливаа заалтад нийцэж байх нөхцөлийг хангах үүрэгтэй.

4.3. Хөрөнгийн бирж нь өөрийн гишүүн байгууллага, бүртгэлтэй компаниуд хөрөнгийн биржийн болон Хорооны дүрэм, журмыг хэрхэн мөрдөж байгаад байнгын хяналт шалгалт хийх үүрэгтэй.

4.4. Хөрөнгийн бирж бүртгэлтэй компаниудад тухайн бирж дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэгслүүд нь хууль тогтоомжид заасны дагуу шударга, ил тод арилжаалагдах нөхцөлийг хангаж буй эсэхэд хяналт тавина.

Тав. Бүртгэлтэй компанийн нийтлэг үүрэг

5.1. Хороо нь бүртгэлтэй компани, түүний эрх бүхий албан тушаалтан, мэргэжлийн зөвлөхөөс дор дурдсан үүргээ биелүүлэх шаардлагыг тавина.

5.1.1. эрх бүхий албан тушаалтан нь өөрийн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авахыг;

5.1.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хорооноос баталсан холбогдох дүрэм, журмыг даган мөрдөх нөхцөлийг үйл ажиллагаандаа мөрдөж, тогтмол хэрэгжүүлж ажиллахыг;

5.1.3. өөрийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчид шударга, тэгш хандахыг;

5.1.4. үнэт цаас эзэмшигч, хөрөнгө оруулагчид мэдээлэл хүргэхдээ тухайн үнэт цаасны хувьд хуурамч зах зээл бий болгохоос урьдчилан сэргийлэх, үүсгэхгүй байхыг;

5.1.5. ижил нөхцөл бүхий нэг төрлийн үнэт цаас эзэмшиж буй үнэт цаас эзэмшигчдэд тухайн бүртгэлтэй үнэт цаастай холбоотой асуудлаар тэгш эртэй хандахыг.

5.2. Хороо нь бүртгэлтэй компани, түүний ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнууд Компанийн тухай хууль, Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-д заасан компанийн сайн засаглалын зарчимыг хангаж ажиллахыг шаардана.

Зургаа. Гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасны бүртгэл, давхар бүртгэл

6.1. Гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй хуулийн этгээд Хорооны зөвшөөрлөөр үнэт цаасаа хөрөнгийн биржид бүртгүүлэн арилжаалахад энэ журам нэгэн адил хамаарна.

6.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 14.2, 18.4-т зааснаар Хорооны баталсан “Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаад улсын хөрөнгийн биржийн жагсаалт”-нд хамаарах биржид бүртгэлтэй гадаадын компани нь хөрөнгийн биржид үнэт цаасаа арилжаалах зөвшөөрөл авах хүсэлтийг Хороонд гаргахад дараах шаардлагыг хангана:

6.2.1. гадаад улсын зохицуулах байгууллага, хөрөнгийн биржид бүртгүүлсэн үнэт цаасны танилцуулга, нэмэлт танилцуулга, бусад холбогдох хавсралтын нотариатаар баталгаажуулсан хуулбар, тэдгээрийн монгол хэл рүү орчуулсан хувь;

6.2.2. хөрөнгийн биржид үнэт цаасаа бүртгүүлэх өргөдөл, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон энэ журмын дагуу бэлтгэсэн болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 18.3-т заасан шаардлагыг хангасан үнэт цаасны танилцуулга.

6.3. Монгол Улсад үндсэн үйл ажиллагаагаа эрхлэдэг, гадаад улсад байгуулж, тухайн улсын бүртгэлд бүртгэгдсэн, аль нэг гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлээгүй боловч Монгол улсад үнэт цаасаа анх удаа бүртгүүлж, хөрөнгийн бирж дээр арилжаалахыг хүсч буй гадаадын компани Хорооноос зөвшөөрөл хүсэхэд энэ журмын 6.2.2-т заасан шаардлагыг хангасан байна.

6.4. Үндсэн үйл ажиллагаагаа гадаад улсад явуулдаг, гадаад улсад байгуулагдаж улсын бүртгэлд бүртгэгдсэн, аль нэг гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлээгүй боловч Монгол улсад үнэт цаасаа анх удаа бүртгүүлж, бирж дээр арилжаалах зөвшөөрөл хүсч буй гадаадын компани нь энэ журмын 6.2.2-т заасан бүх шаардлагыг хангасан байхаас гадна Монгол улсын нутаг дэвсгэрт төлөөлөгчийн газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулан ажиллах үүрэгтэй.

6.5. Хөрөнгийн биржид бүртгэлтэй компани үнэт цаасаа гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлэн арилжаалж болох бөгөөд энэ талаар аливаа мэдэгдэл хийхээс өмнө Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.2-д зааснаар Хороонд бүртгүүлнэ.

6.6. Энэ журмын 6.5-т зааснаар Хороонд бүртгүүлэхдээ дараах бичиг баримтыг Хороонд хүргүүлнэ:

6.6.1. гадаад улсын зохицуулах байгууллага, хөрөнгийн биржид үнэт цаасаа бүртгүүлэхэд тавигдах шаардлага, бичиг баримтын нотариатаар баталгаажуулсан хуулбар;

6.6.2. гадаад улсын зохицуулах байгууллага, хөрөнгийн бирж тухайн компанийн үнэт цаасыг бүртгэсэн тухай шийдвэр гарсан тохиолдолд уг шийдвэрийн хувийг ажлын 1 өдөрт багтаан ирүүлнэ;

6.6.3. Гадаад улсын үнэт цаасны анхдагч зах зээлд арилжигдсан үнэт цаасны хэмжээ, үнэ, зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн нийт дүнгийн тухай тайланг тухайн улсын холбогдох байгууллагад хүргүүлсэнээс хойш ажлын 1 өдөрт багтаан ирүүлнэ.

6.7. Хороо энэ журмын 6.6.2-т заасан шийдвэрийн хувийг хүлээн авсан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.2-д зааснаар уг үнэт цаасыг Хорооны бүртгэлд бүртгэх үндэслэл болно.

6.8. Монгол Улсын улсын бүртгэлд бүртгэгдсэн хязгаарлагдмал хариуцлагатай компани гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлэхэд энэ тухай Хороонд мэдэгдэнэ. Уг мэдэгдэлд энэ

журмын 6.6.1-д заасан мэдээллийн агуулга, 6.6.2, 6.6.3-г заасан мэдээллийг бүрэн эхээр нь хавсаргасан байна.

6.9. Хороо энэ журмын дагуу давхар бүртгүүлэх тухай хүсэлтийг хянах явцад болон цаашид гадаад улсын зохицуулагч байгууллагатай байгуулсан олон талт буюу хоёр талт санамж бичгийн хүрээнд гадаадын зохицуулах байгууллагаас тухайн компанийн талаарх мэдээлэл авч хамтран ажиллаж болно.

6.10. Хороо үнэт цаасны давхар бүртгэлийг үнэт цаасны бүртгэлд бүртгэж, энэ талаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу нийтэд мэдээлнэ.

6.11. Хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны журмаар тогтоосон хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, мэдээллийг хүргэх, ил тод байдлын талаарх шаардлагаас дугуугүй түвшинд шаардлага тавигддаг, эдгээр шаардлагын талаар хөрөнгө оруулагчид мэдээллийг хугацаанд нь хүлээн авах боломж бүрдсэн гэж үзсэн гадаадын хөрөнгийн биржийг энэ журмын 6.2-д заасан “Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаад улсын хөрөнгийн биржийн жагсаалт”-нд оруулах зарчмыг баримтална.

6.12. Хорооны бүртгэлд үнэт цаасаа бүртгүүлэх буюу зөвшөөрөл хүсч буй гадаадын компани энэ журамд заасан аливаа баримт бичгийг монгол, англи хэлээр 2 хувь боловсруулна.

6.13. Энэ журмын 6.12-г заасан мэдээлэлд “Нийтэд толилуулах мэдээллийн тойм” гэж тодотгон бичиж, уг мэдээллийг бүрэн эхээр нь англи хэлээр гадаад улсад болон Монгол Улсад авч болох байгууллага, албан тушаалтны хаяг, цахим хуудсыг зааж, мэдээллийг хүргэх болсон шалтгааныг тайлбарласан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХОРООНЫ ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ

Долоо. Хувьцааны бүртгэл

7.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1.1-д заасан хувьцаат компанийн хувьцааг нийтэд санал болгон гаргахад Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон энэ журамд заасан нөхцөл шаардлагын дагуу Хорооны бүртгэлд бүртгэнэ.

7.2. Үнэт цаас гаргагчийн хувьцааны нийтэд санал болгох, нийтийн эзэмшилд байх хувь хэмжээ, ангилал, шалгуурыг Хорооны зөвшөөрлийг үндэслэн хөрөнгийн бирж тогтооно.

7.3. Хороо энэ журмын 7.1-д заасан үнэт цаасыг бүртгэх үеийн компанийн хувьцаа эзэмшигч, хаалттай хүрээнд худалдан авсан буюу эзэмшсэн тодорхой этгээд болох хувьцаа эзэмшигч, мэргэжлийн эсхүл стратегийн хөрөнгө оруулагчийн эзэмшиж буй үнэт цаасыг тодорхой хугацаанд тусгаарлаж болох бөгөөд тусгаарлалтын хугацааг нэг удаа сунгаж болно.

7.4. Энэ журмын 7.1-д заасан Хорооны бүртгэлд бүртгүүлсэн үнэт цаасыг хөрөнгийн бирж өөрийн бүртгэлийн журмаар тогтоосон шаардлага, шалгуурын дагуу тодорхой ангилалд бүртгэж болно.

Найм. Хувьцаанаас бусад үнэт цаасны бүртгэл

8.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1-д заасан санхүүгийн хэрэгслийг нийтэд санал болгон гаргахад холбогдох журмын дагуу Хорооны бүртгэлд бүртгэнэ.

8.2. Компанийн өрийн хэрэгсэл гаргах тухай танилцуулгад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон энэ журмын холбогдох хэсэг нэгэн адил хамаарна.

8.3. ~~Хороо нь Засгийн газрын өрийн хэрэгсэл, Засгийн газраас бүхэлд нь баталгаа гаргасан үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.2-д зааснаар уг бүртгэлийг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн хийнэ.~~

~~/ Энэхүү хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/~~

8.4. ~~Аймаг, нийслэлийн Засаг дарга өрийн хэрэгсэл гаргах тухай танилцуулгад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5.1-10.5.5, 10.5.7, 10.5.8, 10.5.12, 10.5.16, 10.8, 10.9, 10.11 дэх заалт хамаарахгүй.~~

~~/ Энэхүү хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/~~

8.5. ~~Аймаг, нийслэлийн Засаг дарга өрийн хэрэгсэл гаргах тухай танилцуулгад санхүүгийн мэдээллийн үнэн зөвийг баталж Засаг дарга гарын үсэг зурах бөгөөд Хорооны бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөлд танилцуулгад заасан нөхцөл, хэмжээгээр өрийн хэрэгсэл гаргахыг зөвшөөрсөн тухай тухайн аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолыг хавсаргана~~

~~/ Энэхүү хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/~~

8.6. ~~Хороо энэ журмын 8.4, 8.5 болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан баримт бичгийг хүлээн авч, өрийн хэрэгсэлийн эргэн төлөх баталгаа, барьцаа хөрөнгө, уг өрийн хэрэгсэлээр татах хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн хэрэгжих нөхцөл, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан шаардлага хангасан эсэхийг хянаж Хорооны бүртгэлд бүртгэнэ.~~

~~/ Энэхүү хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/~~

8.7. Үнэт цаас нь бүртгэлийн шаардлагыг хангахгүй болсон бол үнэт цаас гаргагч эсхүл түүний мэргэжлийн зөвлөх энэ тухай Хороонд ажлын 5 өдрийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

Ес. Үнэт цаас гаргагчид тавигдах нийтлэг шаардлага

9.1. Үнэт цаас гаргагч нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

9.1.1. Хорооны бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргагч нь тухайн улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгэгдсэн, гаргасан үнэт цаас нь компанийн дүрэм, холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байх;

9.1.2. өмнө бүртгэгдсэн үнэт цаасны төлбөр бүрэн хийгдсэн, гаргахаар төлөвлөж буй үнэт цаас нь өмчлөх эрхийн зөрчилгүй, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байх;

9.1.3. хүсэлт гаргагч компани нь үнэт цаасаа анхдагч зах зээл дээр гаргаж арилжих хүртэл хугацаанд өөрийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах хэмжээний эргэлтийн хөрөнгөтэй байх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ҮНЭТ ЦААС ГАРГАХАД БЭЛТГЭХ

Арав. Хорооны бүртгэлд бэлтгэх

10.1. Хүсэлт гаргагч нь Хорооны бүртгэлд бүртгүүлэх бэлтгэл шатанд хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй андеррайтер, Хороонд бүртгэлтэй хуулийн, аудитын, үнэлгээний үйл ажиллагаа эрхэлдэг зохицуулалттай хуулийн этгээд болон шаардлагатай бол хөндлөнгийн шинжээчтэй гэрээ байгуулна.

10.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41-д заасан андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь үнэт цаасыг Хорооны болон биржийн бүртгэлд бүртгүүлэх, нийтэд санал болгон арилжаалах ажиллагааг хариуцна.

10.3. Хүсэлт гаргагч, түүнд мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа зохицуулалттай этгээд нь Хорооны бүртгэлд бүртгүүлэхээс өмнө, зохих дарааллын дагуу бичиг баримт, холбогдох дүгнэлтийг боловсруулж бэлдсэн байна.

10.4. Хүсэлт гаргагч нь үнэт цаасаа бүртгүүлэхээр бэлтгэж байгаа талаарх мэдэгдлийг Хороонд бичгээр ирүүлэх бөгөөд энэ мэдэгдлийг үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд ирүүлэх өдрөөс ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө ирүүлнэ.

10.5. Энэхүү журмын 10.4-т заасан мэдэгдлийг Хороонд ирүүлэхэд Хорооны дарга тушаал гаргаж тухайн үнэт цаасыг бүртгэх асуудлаар зөвлөлдөх, шаардлагатай бол тодорхой шаардлага, шалгуураас чөлөөлөх, хүсэлт, холбогдох баримт, материалыг хянах, Хорооны хуралдаанд танилцуулах, гарах шийдвэрийн талаар санал бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажиллуулна.

10.6. Хүсэлт гаргагч нь үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнө энэ журмын 10.5-д заасан ажлын хэсгээс дараах асуудлаар мэдээлэл авч болно:

10.6.1. хүсэлтийг Хороо хүлээн авч Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.6-д заасан хугацааг тоолж эхлэх өдөр;

10.6.2. Хороо Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу хүсэлтийг албан ёсоор хэлэлцэх урьдчилсан тов.

10.7. Хорооны бүртгэлд бэлтгэх шатанд хүсэлт гаргагч нь ажлын хэсэгтэй зөвлөлдөх уулзалтыг тодорхой хуваарийн дагуу зохион байгуулж болно.

10.8. Хорооны бүртгэлд бэлтгэх шатанд хүсэлт гаргагч нь андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй хамтран дор дурьдсан ажиллагааг хэрэгжүүлэн, компанийн үйл ажиллагаанд дүгнэлт өгсөн байна:

10.8.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, дараах асуудлаар дүгнэлт гаргуулсан байна:

10.8.1.1. компани хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх;

10.8.1.2. компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Хорооноос баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал;

10.8.1.3. компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан “Монголын компанийн засаглал кодекс”-т нийцсэн эсэх;

10.8.1.4. бусадтай байгуулсан худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой бусад гэрээ нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх;

10.8.1.5. сүүлийн 1 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх;

10.8.1.6. үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, альваа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх;

10.8.1.7. үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, альваа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх;

10.8.1.8. үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;

10.8.1.9. компанийн толгой, охин, хараат, зэргэлдээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь хэн болохыг тодорхойлох;

10.8.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.3-т заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, дараах асуудлаар дүгнэлт гаргуулсан байна:

10.8.2.1. нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан нь “Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт” /цаашид “НББОУС” гэх/-д нийцэж байгаа эсэх;

10.8.2.2. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь НББОУС-д нийцсэн тайлан гаргах шаардлага, хувь нийлүүлсэн хөрөнгө болон түүний ашиглалтын үр ашигтай байдлыг хангаж чадах эсэх;

10.8.2.3. үнэт цаасны танилцуулга, хавсаргасан бичиг баримтад тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь бодит байдалд нийцэж байгаа эсэх.

10.8.3. Хүсэлт гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.2-т заасан хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, компанийн хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн байх бөгөөд Хороо үнэт цаас гаргагчаас бизнесийн үнэлгээ хийлгэхийг шаардаж болно.

10.8.4. Хүсэлт гаргагч нь шаардлагатай бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.8-д зааснаар хөндлөнгийн шинжээч, мэргэжилтний үнэлэлт дүгнэлт гаргуулж болно.

Арван нэг. Ажлын хэсэгтэй зөвлөлдөх, бүртгэлийн шаардлагаас чөлөөлөх

11.1. Үнэт цаас гаргагч, түүнд мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа зохицуулалттай этгээд нь дараах тохиолдолд Хорооны энэ журмын 10.5-т дурдсан ажлын хэсэгтэй зөвлөлдөнө:

11.1.1. Хорооны бүртгэлийн журмыг хэрхэн хэрэглэх талаар эргэлзээ төрсөн;

11.1.2. энэхүү журмаар тогтоосон тодорхой шаардлага, шалгуураас чөлөөлүүлэх шаардлагатай гэж үзсэн.

11.2. Энэ журмын 11.1-т заасан этгээд энэ журмын 11.1.2-т заасан асуудлаар ажлын хэсэгт бичгээр хүсэлт гаргах бөгөөд түүнд дараах мэдээллийг тусгана:

11.2.1. хүсэлт гаргах болсон үндэслэл, шалтгаан;

11.2.2. бусад шаардлагыг хангаж байгаа эсэр талаарх мэдээлэл;

11.2.3. ажлын хэсэг шийдвэр гаргахдаа анхаарах бусад мэдээлэл;

11.2.4. хүсэлттэй холбоотой нотлох баримт, баримт бичгийн хуулбар.

11.3. Ажлын хэсэг нь энэ журмын 11.1-д заасан этгээдийн хүсэлтийг хөрөнгө оруулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зарчмын үүднээс хянаж, тухайн нөхцөл байдлыг харгалзан, зайлшгүй шаардлагатай гэж үзвэл уг хүсэлт гаргагчид тодорхой нөхцөл хангахыг үүрэг болгох буюу тийнхүү үүрэг болгохгүйгээр энэхүү бүртгэлийн журамд заасан тодорхой шаардлагаас чөлөөлөх тухай шийдвэр гаргах эрхтэй.

11.4. Энэ журмын 11.1-д заасан этгээд нь тухайн хүсэлтийг гаргасан, эсхүл чөлөөлөх шийдвэр гаргаснаас хойш тухайн чөлөөлөлттэй холбоотой нөхцөл байдал өөрчлөгдсөн бол энэ тухай ажлын хэсэгт нэн даруй албан бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

11.5. Энэ журмын 11.4-д заасан тохиолдолд ажлын хэсэг тухайн нөхцөл байдлыг хянаж, өмнөх шийдвэрийг хэвээр үлдээх, өөрчлөлт оруулах шийдвэр гаргана.

ТАВДУГААР БҮЛЭГ ӨРГӨДӨЛ ГАРГАХ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Арван хоёр. Хорооны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргах

12.1. Аливаа үнэт цаасыг бүртгүүлэх тухай өргөдөл нь өмнө нь тухайн төрлийн үнэт цаас бүртгэгдсэн буюу бүртгэгдээгүй байснаас үл хамааран тухайн төрлийн гаргасан буюу гаргахаар төлөвлөж буй бүх үнэт цаасанд хамаарна.

12.2. Хорооны бүртгэлд үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана:

12.2.1. өргөдөл /хавсралт 1-ийн дагуу/;

12.2.2. үнэт цаасны танилцуулга;

12.2.3. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай баримт;

12.2.4. энэ журмын 10.8.1-д заасны дагуу гаргуулсан хууль зүйн дүгнэлт;

12.2.5. энэ журмын 10.8.2-т заасны дагуу гаргуулсан аудитын дүгнэлт;

12.2.6. энэ журмын 10.8.3-т заасны дагуу гаргуулсан хөрөнгийн үнэлгээний тайлан;

12.2.7. энэ журмын 10.8.4-т заасны дагуу хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэн оролцсон бол түүний гаргасан үнэлэлт, дүгнэлт;

12.2.8. энэ журамд заасан бусад нэмэлт бичиг баримт.

Арван гурав. Үнэт цаасны танилцуулгын агуулга, хэлбэр

13.1. Үнэт цаасны танилцуулга нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг агуулсан байх бөгөөд дараах мэдээллийг тусгасан байна:

13.1.1. үнэт цаас гаргагчийн тухай;

13.1.2. хувьцаа эзэмшигчийн тухай;

13.1.3. үнэт цаас гаргагчийн удирдлага, зохион байгуулалт;

13.1.4. үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтаны талаар;

13.1.5. үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны талаар;

13.1.6. хөрөнгө, өр төлбөр, санхүүгийн байдлын талаар;

13.1.7. өнөөгийн болон ирээдүйн бизнес төлөвлөгөөний талаар;

13.1.8. макро, микро түвшний түүний дотор үйл ажиллагааны болон санхүүгийн эрсдэл, түүнийг бууруулах, тархаан байршуулах арга зам;

13.1.9. гаргах үнэт цаас болон тухайн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийн талаар;

13.1.10. үнэт цаасыг арилжих журам;

13.1.11. хөндлөнгийн дүгнэлт;

13.1.12. хөрөнгө оруулагч шийдвэр гаргахад шаардлагатай гэж Хорооноос үзсэн энэ журамд заасан бусад мэдээлэл.

13.2. Танилцуулгын эхний хуудсанд дараах анхааруулгыг тодоор бичсэн байна:

“Үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь уг үнэт цаасны эрсдлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.”

13.3. Үнэт цаасны танилцуулга нь дараах шаардлага хангасан байна.

13.3.1. үнэт цаасыг бүртгүүлэх тухай өргөдөл, үнэт цаасны танилцуулгад үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, андеррайтер хийсэн зохицуулалттай этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал нар гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна;

13.3.2. үнэт цаасны танилцуулга нь 400-гаас илүүгүй хуудастай байна;

13.3.3. үнэт цаасны танилцуулгын бүх хуудсыг нэг бүрчлэн дугаарлаж, үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, андеррайтер хийсэн зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирал нар хуудас бүрийн баруун доод буланд гарын үсэг зурж, тийнхүү гарын үсэг зурсан огноог бичсэн байна;

13.3.4. үнэт цаасны танилцуулгыг гадаад хэлнээ боловсруулсан бол баталгаат Монгол орчуулгыг хавсаргана;

13.3.5. нотариатаар гэрчлүүлэх шаардлагатай бүх баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нотариатаар гэрчлүүлсэн байх.

13.4. Үнэт цаасны танилцуулгын Хороо болон биржид хүргүүлэх хуулбарт хүсэлт гаргагчийн дотоод хяналтын албаны дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж, үнэн зөв гэдгийг баталгаажуулна.

Арван дөрөв. Үнэт цаасны танилцуулгад тусгавал зохих нэмэлт мэдээлэл

14.1. Үнэт цаасны танилцуулгад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5-д заасан мэдээллийг тусгах бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол Хороо нь тодорхой төрлийн буюу энэхүү журмын 2.1.6-д заасан үнэт цаасны танилцуулгад нэмэлт мэдээлэл тусгахыг шаардаж болно.

14.2. Үнэт цаас гаргагч нь дараах тохиолдолд үнэт цаасны танилцуулгыг ажлын хэсэгт хүргүүлснээс хойш, Хорооны бүртгэлд бүртгэх шийдвэр гарч, хөрөнгийн бирж дээр арилжаа хийж эхлэх хүртэл хугацаанд үнэт цаасны нэмэлт танилцуулгыг Хороонд хүргүүлж бүртгүүлэх үүрэгтэй:

14.2.1. үнэт цаасны танилцуулганд тусгаж, нийтэд хүргэвэл зохих мэдээллийн агуулгад өөрчлөлт орсон;

14.2.2. үнэт цаасны танилцуулгыг бэлтгэснээс хойш түүнд заавал тусгавал зохих шинэ үйл явдал болсон;

14.2.3. нэмэлт мэдээлэл оруулахыг Хороо шаардсан.

14.3. Энэ журмын 10.6.1-д заасан хугацааг тооцох зохицуулалт нь үнэт цаасны нэмэлт танилцуулгад нэгэн адил хамаарна.

14.4. Хүсэлт гаргагч энэ журамд заасны дагуу өргөдөл, танилцуулга, бичиг баримтыг зохих шаардлагын дагуу бүрдүүлж Хороонд цахим хэлбэрээр /PDF/ болон хэвлэмэл хэлбэрээр нэг эх хувь, хуулбар хоёр хувийг ажлын хэсэгт хүргүүлнэ.

Арван тав. Үнэт цаасны танилцуулгын талаар хариуцлага хүлээх

15.1. Үнэт цаасны танилцуулга, түүний салшгүй хэсэг болох энэ журмын 12.2.4-12.2.7-д заасан дүгнэлт, тайланд тухайн бичиг баримтын агуулгыг хариуцна гэдэг мэдэгдлээ холбогдох эрх бүхий албан тушаалтан нь заавал бичсэн байна.

15.2. Үнэт цаасыг бүртгүүлэх тухай өргөдөл, үнэт цаасны танилцуулгад гарын үсэг зурж баталгаажуулсан үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, андеррайтер хийсэн зохицуулалттай этгээдийн ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал компанийн эрх бүхий албан тушаалтнууд үнэт цаасны танилцуулгын үнэн зөв байдлын талаар хариуцлага хүлээнэ.

15.3. Энэ журмын 12.2.4-т заасан хууль зүйн дүгнэлтийн талаар түүнд гарын үсэг зурсан хуульч, тухайн хуулийн зөвлөгөөг өгсөн хуулийн этгээд хамтран, 12.2.5.-д заасан аудитын дүгнэлтийн талаар түүнд гарын үсэг зурсан аудитор, тухайн аудитын үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээд хамтран, 12.2.6.-д заасан хөрөнгийн үнэлгээний тайлангийн талаар түүнд гарын үсэг зурсан хөрөнгийн үнэлгээчин, тухайн хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээд хамтран, 12.2.7.-д заасан дүгнэлт, тайлангийн талаар түүнд гарын үсэг зурсан хөндлөнгийн шинжээч буюу мэргэжилтэн, 13.3.4.-т заасан орчуулгын агуулгаар тухайн орчуулагч, 13.4.-д заасан хуулбарын үнэн зөвийг дотоод хяналтын албаны дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хамтран тус тус хариуцлага хүлээнэ.

15.4. Үнэт цаасны танилцуулгын аль нэг хэсгийг дээр дурдсанаас өөр гуравдагч этгээд хариуцан боловсруулсан бол үнэт цаасны танилцуулга бүхэлдээ буюу түүний тодорхой хэсгийн агуулга үнэн зөв болохыг хариуцна гэдэг мэдэгдлийг үнэт цаасны танилцуулгад бичих бөгөөд энэ тохиолдолд үнэт цаас гаргагч, эсхүл түүний эрх бүхий албан тушаалтны мэдэгдэлд холбогдох өөрчлөлт оруулж болно.

Арван зургаа. Хорооны үнэт цаас гаргагчаас мэдээлэл шаардах эрх

16.1. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21.1-д зааснаас гадна, дараах мэдээллийг нэн даруй Хороонд хүргүүлэх үүрэгтэй:

16.1.1. Хорооны бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гаргахад зайлшгүй шаардлагатай гэж Хороо үзсэн мэдээлэл, тайлбар;

16.1.2. хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай гэж Хороо үзсэн аливаа мэдээлэл;

16.1.3. компанийг худалдан авах эсхүл компани өөрчлөн байгуулах явцад хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахад шаардлагатай гэж Хороо үзсэн аливаа мэдээлэл;

16.1.4. бүртгэлийн шаардлагыг хангасан буюу хангасан хэвээр байгааг баталгаажуулах зорилгоор Хороо зайлшгүй шаардлагатай гэж үзсэн аливаа мэдээлэл, тайлбар.

16.2. хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс шаардлагатай гэж үзсэн зохих мэдээллийг тогтоосон хэлбэрээр, тодорхой хугацаанд нийтлэхийг хэдийд ч үнэт цаас гаргагчаас шаардаж болно.

16.3. Үнэт цаас гаргагч энэхүү журмын 16.2-д заасан шаардлагыг хэрэгжүүлээгүй бол мэдээллийг ямар шалтгаанаар нийтлэх шаардлагагүй гэж үзсэн тухай үнэт цаас гаргагчид тайлбар ирүүлэх боломж олгож, уг мэдээллийг Хороо олон нийгэд толилуульж болно.

16.4. Үнэт цаас гаргагч хөрөнгийн биржид хүргүүлсэн эсхүл Хороогоор дамжуулан нийтэд танилцуулсан аливаа мэдээлэл нь худал, төөрөгдүүлсэн, алдаатай эсхүл хоорондоо зөрүүтэй мэдээлэл агуулаагүй, эсхүл уг мэдээлэлд тусгавал зохих аливаа нөхцөл байдлыг орхигдуулаагүй гэдгийг баталгаажуулах шаардлагатай арга хэмжээ авч, мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ
ХОРОО ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫГ БАТАЛЖ,
ҮНЭТ ЦААСЫГ ХОРООНЫ БҮРТГЭЛД БҮРТГЭХ,
БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ

Арван долоо. Үнэт цаасыг Хорооны бүртгэлд бүртгэх

17.1. Хороо энэ журмын тавдугаар бүлэгт заасны дагуу бүрэн гүйцэд хүргүүлсэн бичиг баримтыг хянаж, хууль буюу энэ журамд заасан бүртгэхээс татгалзах үндэслэл байхгүй бол үнэт цаасны танилцуулгыг бүртгэж, үнэт цаасыг бүртгэлд бүртгэх тухай Хороо тогтоол гаргана.

17.2. Хороо нь Хорооны бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлтийг хянах явцад дараах эрх хэмжээтэй байна:

17.2.1. шаардлагатай гэж үзсэн аливаа лавлагаа, нэмэлт мэдээлэл хүргүүлэхийг шаардах, бусад зохицуулагч байгууллага, хөрөнгийн биржтэй зөвлөлдөх;

17.2.2. хөрөнгийн биржээс санал, дүгнэлт гаргуулан авах;

17.2.3. Хорооны бүртгэлд бүртгүүлэх хүсэлттэй холбоотой гэж үзсэн аливаа асуудлаар хүсэлт гаргагч буюу түүний мэргэжлийн зөвлөхөөс асуулт асууж, тайлбар авах;

17.2.4. Хорооны бүртгэлд бүртгүүлэх хүсэлттэй холбоотой гэж үзсэн аливаа мэдээллийг хянах;

17.2.5. хүсэлт гаргагчаас хүргүүлсэн мэдээллийг Хорооноос тогтоосон хэлбэрээр баталгаажуулахыг шаардах;

17.2.6. хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа, ирүүлсэн баримт бичиг нь бодит байдалд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах зорилгоор газар дээрх үзлэгийг хийх;

17.2.7. Хорооноос шаардлагатай гэж үзсэн аливаа нэмэлт нөхцөлийг хүсэлт гаргагчид тогтоох.

17.3. Үнэт цаасны танилцуулгыг Хорооны бүртгэлд бүртгэх тухай Хорооны шийдвэрийг үнэт цаас гаргагчид хүргүүлж, Хороо болон хөрөнгийн бирж өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

17.4. Хүсэлт гаргагч нь дор дурдсан бичиг баримтын хуулбарыг Хорооны бүртгэлд бүртгэх тухай тогтоол гарснаас хойш таван жилийн хугацаанд хадгална:

17.4.1. үнэт цаас гаргахтай холбоотой эсхүл хөрөнгө, бизнес, хувьцааны худалдан авалтыг санхүүжүүлэх зорилгоор үнэт цаас гаргаж байгаа бол тухайн хөрөнгө, бизнес, хувьцааг худалдаж авах тухай гэрээ хэлцэл;

17.4.2. үнэт цаасны танилцуулга боловсруулахад ашигласан аливаа албан тоот, тайлан, үнэлгээ, гэрээ буюу бусад бичиг баримт;

17.4.3. Хорооны бүртгэлд бүртгэх шийдвэр гаргахад хүчин төгөлдөр үйлчилж байсан хүсэлт гаргагчийн дүрэм;

17.4.4. хүсэлт гаргагчийн болон түүний аливаа батлан даагчийн, хүсэлт гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгасан санхүүгийн тайлан мэдээг хамрах тайлант хугацаа тус бүрийн жилийн тайлан, бусад санхүүгийн тайлан;

17.4.5. сүүлийн жилийн тайлангаас хойш болон Хорооны бүртгэлд бүртгүүлэхийг зөвшөөрсөн өдөр хүртэлх хугацаанд гарсан хагас жилийн буюу улирлын санхүүгийн тайлан;

17.4.6. өмчлөх эрхийг гэрчлэх аливаа баримт бичиг;

17.4.7. Хорооны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт нь ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр /ESOP/-тэй холбоотой бол тухайн хөтөлбөрийг гэрчлэх баримт бичиг, хувьцаа хуваарилах, хувьцаа гаргахтай холбоотой хүсэлт гаргагчийн эрх бүхий этгээдийн тушаал, шийдвэрүүд.

17.5. Хүсэлт гаргагч нь Хорооноос шаардлага хүргүүлмэгц энэ журмын 17.4.1-17.4.7-д заасан баримт бичгийг хүргүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлсэн байна.

Арван найм. Үнэт цаасны танилцуулгыг олон нийтэд танилцуулах

18.1. Хороо үнэт цаас, түүний танилцуулгыг бүртгэх тухай тогтоол гаргасан нь уг үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгохыг зөвшөөрөх үндэслэл болно.

18.2. Үнэт цаас гаргагч Хороонд бүртгүүлээгүй үнэт цаасны танилцуулгыг нийтэд танилцуулахыг хориглоно.

18.3. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас, үнэт цаасны танилцуулга болон нэмэлт танилцуулгыг Хороо бүртгэснээс хойш зургаан сарын хугацаанд нийтэд танилцуулах бөгөөд уул хугацаа дууссан өдрөөс хойш тухайн үнэт цаасыг нийтэд санал болгохыг хориглоно.

Арван ес. Үнэт цаасыг бүртгэхээс татгалзах

19.1. Хороо Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.10-т зааснаас гадна тухайн үнэт цаас нь Монгол улсаас өөр улсад бүртгэлтэй бөгөөд үнэт цаас гаргагч нь тухайн орны үнэт цаасны бүртгэлтэй холбоотой хууль тогтоомжийн шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн үнэт цаасыг Хорооны бүртгэлд бүртгэхээс татгалзаж, хүсэлт гаргагчид бичгээр хариу өгнө.

19.2. Хороо нь үнэт цаасыг тодорхой үйл явдлаас шалтгаалах болзолтойгоор Хорооны бүртгэлд бүртгэхгүй.

19.3. Хороо шаардлагатай гэж үзвэл үнэт цаасыг Хорооны бүртгэлд бүртгэхээс өмнө тухайн бүртгэл нь тодорхой үйл явдлаас шалтгаалах болзолгүй талаарх баталгааг үнэт цаас гаргагчаас бичгээр гаргуулан авна.

19.4. Хүсэлт гаргагч нь үнэт цаасыг бүртгэхээс татгалзсан тухай Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд холбогдох журмын дагуу гомдол гаргах эрхтэй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ
ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, АРИЛЖААГ ЗОГСООХ,
БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

Хорь. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах

20.1. Нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах хэлбэрээр хувьцаат компанийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх, нэмж үнэт цаас гаргах, хувьцааг хуваах, нэгтгэх, нийтэд санал болгон гаргасан компанийн бондын арилжаалагдаагүй үлдэгдлийг хүчингүй болгох болон үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахад үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орно.

20.2. Компанийн хэлбэрийг өөрчлөх, үнэт цаас нэмж гаргах, хуваах, нэгтгэх тухай асуудлыг тухайн компани хувьцаа эзэмшигчдийн хурлаар, өрийн бичгийн үлдэгдлийг хүчингүй болгох асуудлыг анх өрийн бичиг гаргах асуудлыг шийдвэрлэсэн эрх бүхий этгээдийн шийдвэрээр гаргана.

20.3. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 20.2-т заасан шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлт, холбогдох шийдвэр, баримт бичгийн бүрдлийн хамт Хороонд хүргүүлнэ.

20.4. Компани нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах болон хувьцааг хуваах, нэгтгэх шийдвэрийг Компанийг тухай хуульд заасан журмын дагуу гаргах бөгөөд уг шийдвэр болон өөрчлөн байгуулах журамд дараах зүйлийг тусгасан байна:

20.4.1. компани нийлэх, нэгдэх, хуваагдах болон үнэт цаасыг хуваах, нэгтгэх нөхцөл, уг ажиллагааг гүйцэтгэх журам;

20.4.2. өөрчлөн байгуулагдаж буй компанийн хувьцааг өөрчлөлтөөр бий болж буй компанийн хувьцаанд хөрвүүлэх харьцаа, холбогдох тооцоолол;

20.4.3. өөрчлөн байгуулалтаар бий болж байгаа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ, өр төлбөр, эрх, үүрэг, хариуцлага болон түүнийг хэрхэн шилжүүлэх тухай мэдэгдэл;

20.4.4. компани өөрчлөн байгуулахтай холбоотой үүсэх хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөө, журам;

20.4.5. хувьцаат компани нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болон өөрчлөн байгуулагдаж байгаа тохиолдолд тухайн компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцааг эргүүлэн авах, хувьцааг хувааж, нэгтгэж байгаа тохиолдолд хувьцааны бутархай үлдэгдлийг худалдан авах үнийг тогтоосон байна.

20.5. Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авах үнийг тогтоохдоо Компанийн тухай хуулийн 55.6-д заасны дагуу хөндлөнгийн үнэлгээний байгууллагаас гаргасан дүгнэлтийг үндэслэх ба хэрэв уг үнийг үнэлгээ хийхийн өмнөх сүүлийн 6 сарын хөрөнгийн бирж дээрх тухайн хувьцааны арилжааны дундаж ханшаас доогуур тогтоосон бол үнэлгээний байгууллага болон ТУЗ-өөс үнийг хэрхэн тогтоосон тухай тайлбар, нотлох баримтыг Хороонд ирүүлнэ.

20.6. Хувьцааг хуваах, нэгтгэх төсөлд хувьцааны бутархай үлдэгдлийг компанийн ТУЗ-өөс тогтоосон үнээр худалдан авах, хувьцаа эзэмшигч хүсвэл зөрүүг мөн үнээр тооцож компанид төлснөөр бүхэл хувьцаа эзэмших эрхтэй байхаар заасан байна.

20.7. Компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хуралд тухайн асуудлаар эсрэг саналтай байсан болон хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай мэдэгдлийг хурлын зар мэдээ хүргэх журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх ажлыг зохион байгуулна.

/ Энэхүү хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

20.8. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг уг шийдвэрийг гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын материал болон дараах баримт бичгийн хамт Хороонд хүргүүлнэ.

20.8¹. Хороо бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой нэмэлт баримт бичгийг шаардаж болох бөгөөд энэхүү шаардлага хүргүүлснээс хойш ажлын тав хоногт уг баримт бичгийг ирүүлээгүй бол Хорооны улсын байцаагч үнэт цаасны арилжааг сэргээнэ.

/ Энэхүү хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор нэмсэн/

20.8.1. хөрөнгийн бирж болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас тухайн компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой санал, дүгнэлт, хамтран байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг тус тус биелүүлж ажилладаг тухай тодорхойлолт;

20.8.2. ногдол ашиг хуваарилсан байдал, ногдол ашгийн үлдэгдэлтэй бол уг хөрөнгийг хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны хадгаламж дахь дансанд байршуулсан тухай баримт.

20.8.3. Компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, эсрэг саналтай байсан болон өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардсан хувьцаа эзэмшигчдийн хувьцаанд ногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг зуучлуулан тараалгахаар үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай байгуулсан гэрээ.

/ Энэхүү заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор нэмсэн/

20.9. Хороо бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг хянаж үзээд хууль болон энэ журамд заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл бүртгэлд өөрчлөлт оруулахаас татгалзаж болно.

20.9¹. Үнэт цаасны бүртгэлийн журмын 20 дугаар зүйлийн 20.8.3-д заасан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын харилцах дансанд байршуулна.

/ Энэхүү хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор нэмсэн/

20.10. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай Хорооны шийдвэр гарсны дараа ажлын 5 хоногт багтаан Ажлын алба үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах бөгөөд энэ тухай ажлын 10 хоногт багтаан улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

Хорин нэг. Үнэт цаасны арилжааг зогсоох

21.1. Хорооны улсын байцаагч нь зах зээлийн хэвийн үйл ажиллагаа эрсдэлд орсон буюу орж болзошгүй, эсхүл хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл дараах үндэслэлээр үнэт цаасны арилжааг зогсооно:

/ Энэхүү хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

21.1.1. бүртгэлийн шаардлага хангахгүй болсон;

21.1.2. үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасан хоёрдогч зах зээлийн мэдээллээ нийтэд толилуулах үүргээ биелүүлээгүй;

21.1.3. үнэт цаас гаргагч нь хууль, журмын дагуу санхүүгийн мэдээллээ нийтэд мэдээлээгүй;

21.1.4. дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох шаардлага үүссэн;

21.1.5. үнэт цаас гаргагч нь санхүүгийн байдлаа үнэн зөв үнэлж, зах зээлд оролцогчдыг холбогдох мэдээллээр хангах чадваргүй болсон;

21.1.6. үнэт цаас гаргагчийн өөр хөрөнгийн бирж дээрх тухайн үнэт цаасны арилжааг эрх бүхий байгууллага нь зогсоох эсхүл түдгэлзүүлсэн;

21.1.6¹. Үнэт цаасны бүртгэлээс хасуулах хүсэлт гаргасан.

/ Энэхүү заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор нэмсэн/

21.1.7. Хороо шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдолд.

21.2. Үнэт цаасны арилжааг зогсоосон нь үнэт цаас гаргагчийг хууль болон энэ журамд заасан мэдээллийг ил тод болгох болон бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

21.3. Хороо үнэт цаасны арилжааг зогсоох тухай шийдвэрт уг шийдвэрийг цуцлах нөхцөлийг тодорхой тусгана.

21.4. Хороо үнэ ханшийг тодорхой түвшинд байлгах зорилгоор үнэт цаасны арилжааг зогсоож болохгүй.

21.5. Бүртгэлтэй компанийн хувьцаа нь нийтийн эзэмшилд байвал зохих хувиас бага байгааг тогтоовол Хороо уг компанийн үнэт цаасны арилжааг зогсоох хугацааг тогтоох бөгөөд тогтоосон хугацаанд энэхүү хувь хэмжээний нөхцөлийг хангаагүй бол заасан хугацаанд үнэт цаасны арилжааг зогсооно.

21.6. Энэ журмын 21.5-д заасан нөхцөл байдал үүсч үнэт цаасны арилжааг нь зогсоосон өдрөөс хойш ажлын 28 өдрийн дотор нийтийн эзэмшилд буй бүх хувьцааг сүүлийн зургаан сарын зах зээлийн жигнэсэн дундаж ханшаас багагүй үнээр худалдаж авна.

21.7. Нийтийн эзэмшилд буй хувьцааны зах зээлийн үнэ тогтоогүй бол компани нийтийн эзэмшилд буй бүх хувьцааг анхны худалдагдсан үнээр худалдаж авна.

21.8. Бүртгэлтэй компани нь энэ журмын 21.6-д заасан хугацаанд нийт хувьцааны нийтийн эзэмшилд байвал зохих хувь хэмжээний нөхцөлийг хангаж Хорооны бүртгэлд хэвээр үлдэх хүсэлт гаргавал Хороо тухайн компанийн үнэт цаасны арилжааг сэргээнэ.

Хорин хоёр. Үнэт цаас гаргагчийн хүсэлтээр бүртгэлээс хасах

22.1. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа Хорооны бүртгэлээс хасуулах хүсэлтэй бол асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн байна.

22.2. Үнэт цаас гаргагч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон үнэт цаас эзэмшигчдэд зориулсан зар мэдээг энэ журмын 20.8.1, 20.8.2-г тус тус заасан баримт бичгийн хамт Хороонд хүргүүлнэ.

22.3. Хороо дээрх шаардлага хангасан эсэхийг хянаж, зар мэдээг олон нийтэд мэдээлж болох тухай үнэт цаас гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

22.4. Энэ журмын 22.3-г заасан зард бүртгэлээс хасуулах тухай шийдвэрийн үндэслэл, нийтэд мэдээлэхийг Хорооноос зөвшөөрсөн тухай болон бүртгэлээс хасуулах өдрийг тусгасан байна.

22.5. Үнэт цаас гаргагч нь зар мэдээг холбогдох хувьцаа эзэмшигчдэд хүргэх буюу нийтэд мэдээлэхтэй нэгэн зэрэг үнэт цаасыг бүртгэлээс хасуулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын болон Хорооны шийдвэр, хугацааны талаар Хөрөнгийн биржид мэдээлнэ.

22.6. Үнэт цаас гаргагч дараах үндэслэлээр Хорооны бүртгэлээс хасуулах тухай мэдээллийг Хороонд хүргүүлсэн бол энэхүү журмын 22.5 дахь заалт хамаарахгүй.

22.6.1. үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал хүндэрч, дампуурах, татан буулгахтай холбоотой ажиллагааг эхлүүлэх нөхцөл үүссэн;

22.6.2. үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулахтай холбоотой хэлцэл, бүтцийн өөрчлөлт хийхээр шийдвэрлэсэн бөгөөд тухайн үнэт цаасны бүртгэл нь уг ажиллагааг хэрэгжүүлэхэд саад учруулахаар байгаа бол дараах тайлбарыг үнэт цаас гаргагч нь Хороонд ирүүлнэ:

22.6.2.1. үнэт цаас эзэмшигч, зээлдүүлэгч, тэдгээрийн өмнө хариуцлага хүлээдэг үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтнуудын хамтын ашиг сонирхолд үнэт цаасыг бүртгэлээс хасуулах нь нийцэх тухай үндэслэл;

22.6.2.2. үнэт цаасыг бүртгэлээс хасуулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэр гаргах боломжгүй буюу шаардлагагүй байгаа шалтгаан.

22.7. Үнэт цаасыг бүртгэлээс хасуулах тухай хүсэлтийг тийнхүү хасуулахаар төлөвлөж буй өдрөөс ажлын 20-оос доошгүй өдрийн өмнө Хороонд ирүүлнэ.

22.8. Өрийн хэрэгслийн хувьд үнэт цаас гаргагч нь бүртгэлээс хасуулахыг хүсч байгаа тухай мэдээллийг тухайн үнэт цаас эзэмшигчдэд буюу тэдгээрийн төлөөлөгчдөд үнэт цаасны танилцуулгад заасны дагуу мэдэгдэх үүрэгтэй бөгөөд тухайн асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар урьдчилан хэлэлцүүлж, зөвшөөрөл авахыг шаардахгүй.

Хорин гурав. Өөрчлөн байгуулах, бүтцийн өөрчлөлтийн улмаас үнэт цаасыг бүртгэлээс хасах

23.1. Хороо дараах үндэслэлээр үнэт цаасыг Хорооны бүртгэлээс хасна:

23.1.1. Дампуурлын тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу шүүх буюу эрх бүхий байгууллагын шийдвэр гарч, үнэт цаас гаргагчид хэрэг гүйцэтгэгч, бүрэн эрхт төлөөлөгч томилсон;

23.1.2. Иргэний хууль болон Компанийн тухай хуульд заасан үндэслэлээр үнэт цаас гаргагчийг татан буулгах тухай шийдвэрийг шүүх гаргаж, татан буулгах комисс томилсон;

23.1.3. татан буулгах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт гомдол гаргах хугацаа дууссан;

23.1.4. Хороонд бүртгэлтэй гадаад улсын үнэт цаас гаргагчид 23.1.1-23.1.3-т заасан үндэслэлээр тухайн улсын хуулийн дагуу шийдвэр гарч татан буулгах буюу өөрчлөн байгуулах ажиллагаа эхэлсэн;

23.1.5. үнэт цаас гаргагчийн өөр хөрөнгийн бирж дээрх үнэт цаасыг бүртгэлээс хассан;

23.1.6. үнэт цаас гаргагчийн хувьд татан буулгах комисс, дампуурлын хэрэг гүйцэтгэгч буюу эрх хүлээн авагч томилогдсон;

23.1.7. өрийн хэрэгслийн хувьд төлбөр бүрэн төлөгдсөн.

Хорин дөрөв. Үнэт цаасны бүртгэлээс хасуулах буюу арилжааг зогсоох тухай хүсэлт гаргах

24.1. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа Хорооны бүртгэлээс хасуулах буюу арилжааг зогсоох тухай дараах мэдээлэл бүхий хүснэгтийг Хороонд гаргах ба арилжааг хүсэлт гаргасан өдрөөр тасалбар болгон зогсооно.

/ Энэхүү хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

24.1.1. үнэт цаас гаргагчийн оноосон нэр;

24.1.2. үнэт цаасны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, түүнийг арилжаалж буй хөрөнгийн бирж;

24.1.3. хүсэлт гаргах болсон нөхцөл байдал, үндэслэлийн тухай мэдээлэл;

24.1.4. ~~үнэт цаасыг бүртгэлээс хасуулах буюу арилжааг зогсоохоор төлөвлөж буй өгнөө;~~

/ Энэхүү заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/

24.1.5. Хорооны үнэт цаасны бүртгэлээс хасуулах буюу арилжааг зогсоох тухай үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид буюу олон нийтэд хүргэх зарын загвар, шаардлагатай бол бусад холбогдох баримт бичгийн хуулбар;

24.1.6. хууль, компанийн дүрэм, энэхүү журамд заасан бол хувьцаа эзэмшигчдийн хурлын тэдгээрт нийцүүлэн гаргасан шийдвэр.

24.1.7. Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцааг худалдаж авах санал гаргах үүрэг буюу компанийг худалдан авах тухай санал гаргасан хяналтын багц хувьцаа эзэмшигч нь компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшигчдэд хүргүүлсэн мэдэгдэл, түүнийг хуульд заасан хугацаанд өгснийг нотлох баримт;

24.2. Хороо шаардлагатай бол үнэт цаас гаргагч, түүний хяналтын багц хувьцаа эзэмшигчийн хуулиар хүлээсэн үүргийг хэрхэн биелүүлсэн талаарх мэдээлэл, түүнийг нотлох баримтын хамт шаардаж болно.

24.3. Энэ журамд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны арилжааг зогсоосон хугацаанд үнэт цаасны арилжааг зогсоосон зөрчил бүрэн арилсан бөгөөд үнэт цаасны арилжааг сэргээлгэх тухай үнэт цаас гаргагчийн хүсэлтээр тухайн үнэт цаасны арилжааг Хороо сэргээнэ.

24.4. Энэ журмын 24.3-т заасан хүсэлтийг үнэт цаас гаргагч ирүүлээгүй бол арилжааг зогсоосон хугацаа дуусмагц Хороо тухайн үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай шийдвэр гаргаж болно.

Хорин тав. Үнэт цаасны бүртгэлээс хасуулах буюу бүртгэлийг хучингүй болгох тухай хүсэлтийг цуцлах

25.1. Үнэт цаасны арилжааг зогсоох, үнэт цаасыг бүртгэлээс хасуулах тухай хүсэлт гаргагч нь уг асуудлыг Хороо шийдвэрлэхээс өмнө хэдийд ч уг хүсэлтээ цуцлах эрхтэй. Хүсэлтийг цуцлах болсон үндэслэл, шийдвэрийн хамт Хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

25.2. Үнэт цаас гаргагч нь энэ журмын 25.1-д заасан хүсэлтийг ирүүлсэн нь Хороо үнэт цаасны арилжааг зогсоох эсхүл бүртгэлээс хасах үндэслэл байна гэж үзвэл тухайн шийдвэрийг гаргахад нөлөөлөхгүй.

25.3. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны арилжааг зогсоох эсхүл үнэт цаасыг бүртгэлээс хасуулахаар төлөвлөж байгаа тухай мэдээлэл хийсний дараа уг хүсэлтийг цуцлах шийдвэр гаргасан бол, энэ тухайгаа нэн даруй хөрөнгийн бирж болон нийтэд мэдээлнэ.

Хорин зургаа. Үнэт цаасны арилжааг сэргээх

26.1. Хорооноос үнэт цаасны арилжааг зогсоох шийдвэр гарснаас хойш үнэт цаас гаргагч нь тухайн үнэт цаасны арилжааг сэргээх тухай энэ журмын 24.3-т заасан хүсэлтийг гаргаж болно.

26.2. Үнэт цаас гаргагч нь энэ журмын 26.1-д заасан хүсэлтийг бичгээр Хороонд гаргах бөгөөд уг хүсэлтэд үнэт цаасны бүртгэлийг хучингүй болгосон үндэслэл арилсан тухай нотлох баримтыг хавсаргана.

26.3. Үнэт цаасны арилжааг сэргээх тухай хүсэлтийг Хороо ажлын 20 хоногт багтаан шийдвэрлэнэ.

26.4. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой цаашид үнэт цаасны арилжааг үргэлжлүүлэн зогсоох, эсхүл үнэт цаасыг бүртгэлээс хасах шаардлагүй гэж Хороо үзвэл тухайн үнэт цаасны арилжааг сэргээнэ.

26.5. Хороо арилжааг зогсоосон зөрчил арилсан гэж үзвэл өөрийн санаачлагаар тухайн үнэт цаасны арилжааг сэргээж болно.

26.6. Хороо үнэт цаасны арилжаа сэргээж, арилжаа эхлүүлэх зөвшөөрлийг хөрөнгийн биржид хүргүүлж, энэ талаар нийтэд мэдээлнэ.

Хорин долоо. Гадаадын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэлтэй үнэт цаасны арилжааг зогсоох, сэргээх, бүртгэлээс хассанаас үүсэх харилцаа

27.1. Гадаадын хөрөнгийн бирж, зохицуулах байгууллагаас үнэт цаас гаргагчийн үнэт цаасны арилжааг зогсоох, бүртгэлээс хасах шийдвэр гаргасан бол үнэт цаас гаргагч энэ тухай Хороонд мэдэгдэх үүрэгтэй.

27.2. Үнэт цаас гаргагчийн харьяалах улсын зохицуулах байгууллага, хөрөнгийн биржээс үнэт цаас гаргагчийн үнэт цаасны арилжааг зогсоох, сэргээх, бүртгэлээс хасах тухай хүсэлт Хороонд ирүүлсэн, эсхүл тухайн хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн үнэт цаасны арилжааг тухайн оронд зогсоосон, бүртгэлээс хассан нь Хороо шаардлагатай гэж үзсэнээс бусад тохиолдолд тухайн компанийн үнэт цаасны арилжааг зогсоох, сэргээх, бүртгэлээс хасах үндэслэл болохгүй.

27.3. Хороо нь гадаадын зохицуулах байгууллага, хөрөнгийн биржээс ирүүлсэн хүсэлтийн дагуу үнэт цаасны арилжааг зогсоох, сэргээх, бүртгэлээс хасах шийдвэр гаргах бол үнэт цаас гаргагчид энэ талаар мэдээлэл хүргэнэ.

27.4. Гадаадын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн үнэт цаасны арилжааг зогсоох, сэргээх, бүртгэлээс хасахтай холбоотой харилцаанд энэ журмын холбогдох зохицуулалт нэгэн адил хамаарна.

27.5. Хороо энэ журмын 27.4-т заасан этгээдийн үнэт цаасны арилжааг зогсоох, сэргээх, бүртгэлээс хасах тухай шийдвэр гаргахдаа харьяалах гадаадын зохицуулах байгууллага болон хөрөнгийн биржээс мэдээлэл авах, харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр хамтран ажиллаж болно.

Хорин найм. Хариуцлага

28.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай болон бусад хууль тогтоомжид заасан захиргааны хариуцлагыг Хорооны улсын байцаагч ногдуулна.

28.2. Энэ журмын 1-д заасан захиргааны хариуцлага хүлээлгэсэн нь тухайн этгээдийн бусдын өмнө хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

~oOo~

“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын
Хавсралт-2

АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД НИЙТЭД САНАЛ БОЛГОН ҮНЭТ ЦААС АРИЛЖСАН ТУХАЙ ТАЙЛАН

Огноо:/.../....
Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

1. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

1.1. Оноосон нэр:

1.2. Гаргасан үнэт цаасны нэр, төрөл, тоо

ширхэг, нэрлэсэн үнэ, хугацаа, хүү, код, ISIN код:

1.3. *Оршин байх албан ёсны хаяг /Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын хаягийг мөн бичнэ/:*

1.4. *Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:*

1.5. *Нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий зохицуулагч байгууллагын шийдвэрийн огноо, дугаар:*

1.6. *Анхдагч зах зээлд арилжаалж эхэлсэн болон дууссан огноо:*

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.4.-т заасны дагуу анхдагч зах зээлийн арилжааны тухай дараах тайланг арилжаа нь зохих журмын дагуу явагдсан тухай хөрөнгийн биржийн тодорхойлолтын хамт хүргүүлж байна.

2. Анхдагч зах зээлийн арилжааны мэдээлэл

2.1. *Андеррайтерийн оноосон нэр /синдикат хэлбэрээр оролцсон бол оролцогч талын мэдээллийг мөн бичнэ/:*

2.2. *Анхдагч зах зээлийн арилжааг явуулсан хөрөнгийн бирж:*

2.3. *Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны хувь хэмжээ, тоо ширхэг:*

2.4.1. *Нийтэд санал болгон арилжсан нэгж хувьцааны үнэ /дээд, доод, дундаж ханиш/:*

2.4.2. *Үнэт цаасыг хаалттай захиалгын хүрээнд санал болгон худалдсан бол нэгж хувьцааны үнэ болон хаалттай хүрээнд санал болгон арилжсан тоо, хувь /энэ хэсэгт үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авсан хувьцаа эзэмшигчийн мэдээлэл мөн хамаарна/:*

2.4.3. Ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр /ESOP/ хэрэгжүүлсэн бол нэгж хувьцааг тооцсон үнэ, тэдгээрт эзэмшүүлсэн хэмжээ:

2.4.4. Өрийг хувьцаагаар сольсон бол хувьцаанд хөрвүүлсэн өрийн хэмжээ, нэгж хувьцааг тооцсон үнэ, хөрвүүлсэн хувьцааны тоо:

2.5. Татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн хэмжээ:

2.6. Нийтэд арилжигдсан үнэт цаасны тоо, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ:

2.7. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө нь ТИЙМ ҮГҮЙ* үнэт цаасны танилцуулгад заасан зориулалтаар зарцуулахад хүрэлцээтэй эсэх:

*ҮГҮЙ хариултыг сонгосон бол холбогдох тайлбрыг бичнэ.

2.8.1. Нийтэд санал болгон арилжсан үнэт цаасны төлбөр үнэт цаас гаргагчийн зохих дансанд бүрэн байршсан эсэх:

2.8.2. Өрийг хувьцаагаар сольсон бол зээлдүүлэгчийн дансанд түүний хөрвүүлэн эзэмшсэн хувьцаа бүрэн байршсан эсэх:

2.9. Нийтэд санал болгон анхдагч зах зээлд арилжсан үнэт цаасны 5 болон түүнээс дээш хувийг дангаар эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээдийн эзэмшиж буй үнэт цаасны тоо, хувь:

2.10. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаатай холбоотой нэмэлт тайлбар, мэдээлэл болон уг арилжаатай холбогдох санал, гомдол байгаа эсэх:

Иймд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.6.-д “Хороо үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд арилжсан тухай тайланг ажлын гурван өдөрт багтаан хянах ба зөрчил гараагүй, үнэт цаасны анхдагч

зах зээлийн арилжаа амжилттай болсон гэж үзсэн тохиолдолд үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг олгоно.” гэж заасны дагуу энэхүү тайлангийн 1.2-т заасан үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тайлангийн 2.2-т заасан хөрөнгийн биржид олгоно уу.

Тайлан гаргасан:

1. Овог, нэр:.....

3. Овог, нэр:.....

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....” –ХК-ийн ТУЗ-ийн дарга

Албан тушаал:
андеррайтерийн компанийн ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:.....

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

2. Овог, нэр:.....

4. Овог, нэр:.....

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....” –ХК-ийн гүйцэтгэх захирал

Албан тушаал:
андеррайтерийн компанийн
гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын
Хавсралт-1

**ХОРООНООС НИЙТЭД САНАЛ БОЛГОХЫГ ЗӨВШӨӨРСӨН
ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙ
ӨРГӨДӨЛ**

Огноо:/...../.....
Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

1. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

1.1. Оноосон нэр:

1.2. Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн

дугаар:

1.3. Регистрийн дугаар:

1.4. Үйл ажиллагааны чиглэл:

1.5. Гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл

/5 болон түүнээс дээш хувийг аж ахуйн нэгж эзэмшдэг бол түүний хяналтын багц эзэмшигч бенифициар өмчлөгчийг мөн бичнэ/:

1.6. Оршин байх албан ёсны хаяг

/Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/:

1.7. Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:

Санхүүгийн зохицуулах хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд дараах үнэт цаасыг бүртгүүлэхээр энэхүү өргөдлийг гаргаж байна. Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан холбогдох ... нүүр баримт бичгийг хавсарган хүргүүлэв.

2. Үнэт цаасны мэдээлэл

2.1. Үнэт цаасны нэр:

2.2. Өмнө аль нэгэн хөрөнгийн биржид бүртгэлтэй эсэх болон үнэт цаас гаргасан улс, бүртгэлтэй хөрөнгийн бирж:

2.3. Өмнө нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллага, түүнийг бүртгэсэн хөрөнгийн биржийн шийдвэрийн дугаар, огноо:

2.4. Өмнө гаргасан үнэт цаасны төрөл, нэрлэсэн үнэ, тоо ширхэг, код, ISIN код:

2.5. Анх удаа эсхүл нэмж гаргах үнэт цаасны төрөл:

2.6. Үнэт цаас гаргах хөрөнгийн бирж:

2.7. Тоо ширхэг:

2.8. Нэрлэсэн үнэ:

2.9. Хугацаа, хүү

2.10. Үнэт цаасны нийтэд санал болгох хувь хэмжээ, хэлбэр, үнэ:

2.11. Үнэт цаас гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ:

2.12. Үнэт цаасны нөхцөл /хямдруулсан, хөвөх, тогтмол хүүтэй, хугацаанаас нь өмнө эргүүлэн татах г.м./:

2.13. Үнэт цаасыг нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн хугацаа:

2.14. Үнэт цаас гаргах замаар олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалтын талаарх товч мэдээлэл:

3. Үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөө өгсөн зохицуулалттай хуулийн этгээдийн мэдээлэл

3.1.1. Андеррайтерийн оноосон нэр /синдикат хэлбэрээр оролцож байгаа бол энэ

болон дараах мэдээллийг мөн бичнэ/:

3.1.2. *Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:*

3.1.3. *Регистрийн дугаар:*

3.1.4. *Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо:*

3.1.5. *Оршин байх албан ёсны хаяг /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/:*

3.1.6. *Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:*

3.2.1. *Хуулийн зөвлөгөө өгсөн компанийн оноосон нэр:*

3.2.2. *Бүртгэлтэй улс, бүртгэлийн дугаар:*

3.2.3. *Регистрийн дугаар:*

3.2.4. *Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо:*

3.2.5. *Оршин байх албан ёсны хаяг /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/:*

3.2.6. *Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:*

3.3. *Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаас гаргахтай холбоотойгоор ямар нэгэн хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажилласан болон энэ тухай мэдээлэл:*

Энэхүү өргөдөл, түүнд хавсарган хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг өргөдөл гаргагч бид бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдож болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг үнэт цаасны танилцуулгад үнэн зөв, бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан:

2. Овог, нэр:.....

4. Овог, нэр:.....

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....” –.....К-ийн ТУЗ-ийн дарга

Албан тушаал:
андеррайтерийн компанийн ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:.....

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

3. Овог, нэр:.....

5. Овог, нэр:.....

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....” –.....К-ийн гүйцэтгэх захирал
Гарын үсэг:.....

Албан тушаал:
.....андеррайтерийн компанийн
гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

4. Овог, нэр:.....

6. Овог, нэр:.....

Албан тушаал: Үнэт цаас гаргагч
“.....” –.....К-ийн Ерөнхий нягтлан
бодогч

Албан тушаал: хуулийн
зөвлөх“.....” –ХХК-ийн
гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

Өргөдөл гаргасан огноо:.....

Өргөдөлтэй холбоотой асуудлыг
хариуцан ажиллах ажилтны овог нэр,
албан тушаал, холбоо барих утас:

<i>Өргөдөл хүлээн авсан ажилтаны овог нэр:</i>	<i>Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:</i>	<i>Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:</i>
--	--	--